





2019 оны 9 дүгээр сарын 09-13

НЭГ. ТОХИОЛДОЛД СУУРИЛСАН ТАНДАЛТЫН МЭДЭЭ

Улсын хэмжээнд 2019 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн байдлаар ЗӨСҮТ-д зоонозын халдварын хүний өвчлөлийн сэжигтэй байж болзошгүй нийт **947** яаралтай дуудлагыг хүлээн авсан байна. Эдгээрийн 108(11.4%) галзуугийн эрсдэлд өртсөн, 812(85.7%) хачигт халдвар, 6(0.6%) боом, 7(0.7%) тарваган тахал, 2(0.2%) хумхаа, 1(0.1%) ям, 4(0.4%) денги, 5(0.5%) бэтэг, 3(0.3) бруцеллез өвчний сэжигтэй тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.

1.1. Галзуу өвчний эрсдэлд өртсөн тохиолдол:



Баянхонгор, Булган, Говь-Алтай, Дорноговь, Дундговь, Завхан, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгийн 22 сум, нийслэлийн 4 дүүргээс галзуу өвчний эрсдэлд өртсөн нийт 108 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 4%-иар, эпидемиологийн 36 дугаар долоо хоногтой харьцуулахад 1 тохиолдлоор тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.



Галзуу өвчний сэжигтэй зэрлэг, мал амьтанд уруулж, ноцуулан, шүлсдүүлсэн хүмүүсийн тохиолдлыг эх уурхайгаар нь авч үзвэл: эзэнтэй нохойд (39.8%), чононд (17.6%), эзэнгүй нохойд (14.8%), үнэгэнд (9.3%), үхэрт (7.4%), мануулд (2.8%), мууранд (1.9%), тэмээнд (0.9%) нь уруулж, ноцуулж вакцин, ийлдэс эмчилгээнд хамрагдсан байна.

1.2 Хачгаар дамжих халдварт өвчний сэжигтэй тохиолдол:

Архангай, Баянхонгор, Булган, Баян-Өлгий, Дорнод, Дундговь, Дорноговь, Дархан-Уул, Говьсүмбэр, Говь-Алтай, Өмнөговь, Өвөрхангай, Ховд, Хэнтий, Хөвсгөл, Завхан, Сэлэнгэ, Төв, Увс, Орхон, Сүхбаатар аймгийн 116 сум, нийслэлийн 7 дүүрэгт хачгаар дамжих халдварын 812 сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 24.6%-иар, эпидемиологийн 36 дугаар долоо хоногтой харьцуулахад 3 тохиолдлоор тус тус буурсан үзүүлэлттэй байна.



2019 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн байдлаар ХР-ын 654 сэжигтэй тохиолдлын 118 (18%), ХБ-ын 71 сэжигтэй тохиолдлын 13 (18.3%), ХЭ-ын 87 сэжигтэй тохиолдлын 16 (18.4%) нь тархвар судлал, эмнэл зүй, лабораторийн шинжилгээгээр онош батлагдсан.

1.3 Бруцеллёзын хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдол:

Ховд аймгийн Манхан сумаас бруцеллёзын хүний өвчлөлийн сэжигтэй 1 тохиолдол бүртгэгдсэн. ЗӨСҮТ-ийн лабораторийн шинжилгээгээр өвчтөний цусны ийлдсэнд бруцеллёзын эсрэг бие IgG тодорхойлогдсон.

1.4 Мэрэгч амьтны дуудлага:

2019 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн байдлаар нийслэлийн 5 дүүргийн (БЗД, БГД, СХД, СБД, ХУД) хэмжээнд нийт 59 удаагийн амьтны дуудлаганд үйлчилж, хураагдсан сорьц материалыг ЗӨСҮТ-ийн лабораторид шинжлэхэд тарваган тахал түүнтэй хам тохиолдох өвчин үүсгэгч илрээгүй байна. Энэ долоо хоногт нийслэлийн БГД-ийн 10-р хорооноос ирүүлсэн мэрэгч амьтны (1 ширхэг тарвага) дуудлаганд үйлчилсэн. Сорьцод онош тодруулахаар лабораторийн шинжилгээ хийж байна.

ХОЁР. ТУХАЙН 7 ХОНОГТ БҮРТГЭГДСЭН ЗООНОЗЫН ШАЛТГААНТ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ

Монгол улсад:

Мэрэгч амьтны дуудлага:

Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын “Ангирлаг-Уул” гэдэг газар мэрэгч амьтны (1 ширхэг тарвага) дуудлаганд үйлчилж, хураагдсан сорьц материалыг Баян-Өлгий аймгийн ЗӨСТ-ийн лабораторид шинжлэхэд тарваган тахлын нян илэрсэн. Одоогоор эрсдэлд өртсөн хүн байхгүй байна. ЗӨСҮТ-д сорьцыг баталгаажуулна.

Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн ЗӨСТ

Дархлаажуулалт:

2019 оны 9 дүгээр сарын 05-наас 9 дүгээр сарын 12-ны өдрүүдэд Хэнтий аймгийн Хэрлэн, Дархан, Цэнхэрмандал, Жаргалтхаан, Бор-Өндөр зэрэг сумдын 8 хүн галзуугийн эсрэг дархлаажуулалтанд хамрагдсан байна.

Эх сурвалж: Хэнтий аймгийн ЗӨСТ

Дуут хавдар:


Дорнод аймгийн Булган сумын II-р багийн “Өвөр-Урт” гэдэг газар малчин “У”-ийн 1 тугал 2019 оны 9 дүгээр сарын 06-ны өдөр халдварт өвчний шинж тэмдэгтэй хорогдсон тул сорьц авч аймгийн МЭАЦЛ-д шинжлүүлэхэд “Дуут хавдар” болох нь тогтоогдсон. Тус сумын Засаг даргын захирамжаар 2019 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн А/81 дугаар захирамжаар хязгаарлалтын дэглэм тогтоосон байна. Голомтод 2 өрхийн 92 тугалыг вакцинжуулж ариутгал халдваргүйтгэл хийжээ.

Эх сурвалж: ОБЕГ


Олон улсад:

Эбола вируст халдвар:

2019 оны 9 дүгээр сарын 06-ны өдрийн байдлаар Бүгд Найрамдах Ардчилсан Конго улсад Эбола вируст халдварын сэжигтэй тохиолдол 3054 тохиолдол бүртгэгдсэнээс 2052 (67%) нь нас барсан. Нийт тохиолдлын 1772 58%) нь эмэгтэйчүүд, 865(28%) нь 18-аас доош насны хүүхэд, залуучууд эзэлж байна. Эрүүл мэндийн байгууллагын 156 5%) ажилчид халдвар авсан талаар мэдээлэгдэж байна.



Хүснэгт 1. Эпидемиологийн долоо хоногоор



Зураг 1. Эбола вирус халдварын тархалт, БНАК улс

Эх сурвалж: ДЭМБ

Мал, амьтны шүлхий өвчин:

Замби улсын Мал, амьтны эрүүл мэндийн газрын мэдээгээр 2019 оны 8 дугаар сарын 06-нд Копербэйлт тосгонд “0” хэвшлийн вирусээр үүсгэгдсэн мал амьтны шүлхий өвчин бүртгэгдэж 6 үхэр өвчилсөн байна. Дээрхи тохиолдол нь ДМАЭМБ-ын мал, амьтны өвчлөлийн 2019 оны 9 дүгээр сарын 09-ний өдрийн мэдээнд нийтлэгдсэн байна.

Эх сурвалж: ДМАЭМБ

Баруун нилийн халуурал:

Франц улсын Мал, амьтны эрүүл мэндийн газрын мэдээгээр 2019 оны 9 дүгээр сарын 02-нд Порт-Де-Войст мужийн адууны аж ахуйд Баруун нилийн халуурал өвчний дэгдэлт бүртгэгдэж 25 адуу өртөмхий байснаас 1 адуу өвчилсөн байна. Дээрхи тохиолдол нь ДМАЭМБ-ын мал, амьтны өвчлөлийн 2019 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн мэдээнд нийтлэгдсэн байна.



Африкийн гахайн мялзан өвчин:

Эх сурвалж	Хаана	Мэдээлсэн хугацаа	Өртсөн хугацаа	Нэгж	Өртөмхий	Өвчилж үхсэн	Устгасан
ДМАЭМБ	- Унгар улс - Borsod-Abauj-Zemplen	2019.09.11	2019.08.29	Ойд		22 зэрлэг гахай	
ДМАЭМБ	- Латви улс - Тукума тосгон	2019.09.11	2019.09.02	Ойд		1 зэрлэг гахай	
ДМАЭМБ	- Молдав улс - Ниспорени тосгон	2019.09.11	2019.09.09	Тодорхойгүй	6 гахай	1 гахай	3 гахай
ДМАЭМБ	- Өмнөд Африк - Northern Cape тосгон	2019.09.11	2019.09.03	Ферм	85 гахай	57 гахай	

Эх сурвалж: ДМАЭМБ

ЗӨСҮТ-ийн Шуурхай удирдлагын нэгж